

**НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
Нэг. Хуулиар хүлээсэн үүрэг, удирдлага зохион байгуулалт, авлигатай тэмцэх санал санаачилга, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх чиглэлээр			
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан ажиллах, энэ талаарх мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	Авлигын эсрэг хууль тогтоомж, зохион байгуулж буй арга хэмжээг цахим болон бусад хэлбэрээр сурталчлах	Авлигын эсрэг хуулийн сургалтад байгууллагын эрх бүхий ажилтан сууж, албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, сурталчилгааны хуудас, гарын авлага материалаар хангаж ажилласан.
		Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх зардлыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, тайланг тогтоосон хугацаанд хүргүүлэх	Авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан гарган хэрэгжүүлж ажилласан. Төсөв хүндрэлтэй байгаа үед дотоод нөөц бололцоогоо ашиглан төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр зардал батлаагүй болно. Холбогдох тайланг тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан.
		Хүний нөөцийн ил тод байдлыг хангах	Байгууллагын цахим хуудсанд төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтны ёс зүйн дүрэм, ажлын байрны тодорхойлолт, мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг нийтэлж танилцуулсан. 2016 онд сул ажлын байр гараагүй.
		Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	Байгууллагын эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, хүний нөөцийн бодлогын ил тод байдлын 12 мэдээлэл, байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан, тогтоол, шийдвэрийн 2015 оны гүйцэтгэлийн мэдээ, мэдээллийн ил, тод байдал, 2015 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан, 2015 онд авлигын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, байгууллагын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2016 оны ажлын төлөвлөгөө, 2016 оны сургалтын төлөвлөгөө, 2016 оны Авлигын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, цаг үеийн мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд нийтэлсэн.

2	Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх	Тухайн жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт болон сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг цахим хуудаст байршуулах	Холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн цэс үүсгэж, шилэн дансны нэгдсэн системд 2016 оны төсөв, 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, 2016 оны 1-12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, энэ оны 4 удаагийн санхүүгийн тайлан, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, аудитын дүгнэлт, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тухайн байгууллагын жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, хагас бүтэн жилийн гүйцэтгэлийн KPI, төсвийн тодотгол болон бусад холбогдох мэдээллийг нийтэлсэн.
		Худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	Аудитын програм худалдан авах ажиллагаа /харьцуулалтын арга/-ны зар, шалгаруулалтын дүнг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн.
4	Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	“Нээлттэй Улаанбаатар-2016” Авлигын эсрэг олон улсын 2 дугаар форумд оролцох	“Нээлттэй Улаанбаатар-2016” Авлигын эсрэг олон улсын форум энэ жил зохион байгуулагдаагүй.
		Авлигын эсрэг нийслэлээс явуулж буй бодлого, шийдвэрийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээ мэдээллийг иргэн, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх	Авлигын эсрэг нийслэлээс явуулж буй бодлого, шийдвэрийг дэмжин, энэ талаарх мэдээ мэдээллийг иргэн, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх талаар анхаарч ажилласан.
		Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг олон эх үүсвэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн хугацааг богиносгох	2016 онд иргэнээс албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол ирснийг байгууллагын дэргэдэх ёс зүйн хороо журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж, хариуг иргэнд хуулийн хугацаанд багтаан мэдээлсэн.
		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод аудитын хяналтын тогтолцоог сайжруулах, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, дахин гаргахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах	Нийслэлийн Дотоод аудитын алба нь 2016 онд нийслэлийн Засаг даргын хамрах хүрээний нийт 32 байгууллагад аудитын ажлыг гүйцэтгэсэн. Аудитын ажлын хүрээнд 246 зөвлөмж хүргүүлж, нийт 10,922.3 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 2,461.5 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, 17.1 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулах, 17.5 сая төгрөгийн зөрчлийг акт тогтоож, төсөвт буцаан төвлөрүүлэхээр холбогдох

			байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж өгч ажиллаа.
Хоёр. Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах чиглэлээр			
5	Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, мэдээлэх, хяналт тавих ажлыг хуулийн дагуу зохион байгуулах	Мэдүүлэг гаргагч албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг журмын дагуу зохион байгуулах	АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны шинэчилсэн жагсаалтын дагуу холбогдох 14 албан хаагчийг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган, мэдүүлгийг авч, тайлан мэдээг зохих хугацаанд гаргаж өгсөн. Аудитор, шинжээчдээс аудитын ажил эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 103 мэдэгдэл хүлээн авч АТГ-ын програмд бүртгэсэн.
	Мэдүүлэг гаргагч нарт мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гарын авлага материалаар хангах		
6	Албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн дүрмийг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах	Албан хаагчдад шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаар сургалт зохион байгуулах, шударга байдал, түүнийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын ёс зүйн дүрэм”, “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтны ёс зүйн дүрэм”, “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”, Захиргааны ерөнхий хуулийг байгууллагын цахим хуудсанд нийтэлж, албан хаагч бүрт цахим шуудангаар илгээсэн.
		Ёс зүйн дүрмийн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн бүртгэл хөтлөх, хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх	Ёс зүйн дүрмийн зөрчлийн мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж, НЗДТГ-ын ТЗУХ-т болон нийслэл дэх ТАЗ-ийн салбар зөвлөлд хүргүүлсэн.
		Зөрчил үүссэн болон үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, ёс зүйн хорооны гишүүдийг чадваржуулах	Байгууллагын дэргэдэх ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, даргаар Чанарын хяналтын хэлтсийн дарга Д.Нансалмаа, гишүүдээр Захиргаа, хуулийн хэлтсийн дарга Я.Сарансүх, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн ахлах аудитор Б.Эрдэнэсүрэн нарыг байгууллагын даргын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/04 тушаалаар томилсон. Ёс зүй хорооны гишүүд төрийн захиргааны албан хаагчийн болон дотоод аудиторын, мэргэшсэн нягтлан бодогчийн зэрэг

			холбогдох мэргэжлийн ёс зүйн дүрмүүдийг уншиж судалсан.
7	АТГ-аас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, тайлагнах	АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулахаар хүргүүлсэн албан бичиг, АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн дагуу тодорхой арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах	Албан тушаалд нэр дэвшигч 8 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулж, ирүүлсэн зөвлөмжийн дагуу томилгоог хийсэн. Зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулахаар ирүүлсэн албан бичиг, АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар ирүүлсэн мэдэгдэл байхгүй болно.

ХЯНАСАН:
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЖАВЗАН

ТАЙЛАН БИЧСЭН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Я.САРАНСҮХ

2017 оны 01 дүгээр сарын 13